# III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нийлүүлэх бараа нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

**Барааны нэр: ………………………….**

| *Нэр төрлийн дугаар* | *Бараа болон холбогдох үйлчилгээний нэр* | *Техникийн тодорхойлолт болон стандарт* |
|---|---|---|
| **Багц 1** | **Мах,махан бүтээгдэхүүний багц \үхэр,хонь** | • Лабораторийн шинжилгээний бичиг болон гарал үүслийн бичигтэй байна.<br>• Үхрийн мах нь бүтнээрээ 150 кг аас багагүй жинтэй байна.<br>• Зориулалтын агуулах болон бэлтгэн нийлүүлэгчээс шууд нийлүүлдэг байх<br>• Хүнсийг тээвэрлэх жолооч нь эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байх.<br>• Мах тээвэрлэхдээ зориулалтын нэг тээврийн хэрэгслээр зөөвөрлөх<br>• Мах нь шинэ, чийгээ алдаагүй, технологийн дагуу цэвэрлэж, хөлдөөсөн, гадаргуу цэвэр, гадны үнэр, амт байхгүй байна. /шивтэр, бензин гэх мэт, хэвлийн дайвар бүтээгдэхүүн болон малын ялгадасгүй байх/<br>• Шаардлагатай тохиолдолд захиалагч байгууллага шинжилгээний давтан оруулсан тохиолдолд шинжилгээний төлбөрийг нийлүүлэгч тал хариуцах /төлбөр төлөх/<br>• 2013 оны хүнсний хуулийг хэрэгжүүлсэн байна.<br>• Нийлүүлэгч тал нь өөрсдийн зардлаар хүргэж ирнэ.<br>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна. |
| **Багц 2** | **Төмс, хүнсний ногооны багц** | **Ерөнхий зүйл:**<br>• Нийлүүлэгдэх ногоо нь орон нутагт тариалагдсан, стандартын шаардлага хангасан байна.<br>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар хүргэж ирнэ.<br>• Хорхойд идэгдээгүй байна<br>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.<br>• “Хүнсний тухай хууль” –ийг хэрэгжүүлсэн байна. |

| | | |
|---|---|---|
| | | • Лаборторийн шинжилгээний болон гарал үүслийн бичигтэй байна.<br>58<br>• Хүнсийг тээвэрлэх жолооч нь эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байх.<br>• Тээвэрлэхдээ зориулалтын нэг тээврийн хэрэгслээр зөөвөрлөх<br>**Барааны нэр: Төмс**<br>• Төмсний диаметр 6-7см-ээс багагүй, 1ш төмсний дундаж жин 180-250гр байх<br>• Гэмтэж муудаагүй, зөөлрөөгүй, соёолоогүй, хайрагдаагүй, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна. /гадаргууд нь шороо чулуу наалдаагүй байх/<br>• Стандартын шаардлага хангасан үрээр тарьсан байх /Хятад үрийн төмсөөр тариагүй, монгол газрын тарисан байх/<br>1тн төмс бүрт 10кг хорогдол тооцож түүнтэй тэнцэх хэмжээний төмс нэмж нийлүүлэх<br>**Барааны нэр: Байцаа**<br>• Байцаа нь нягтрал сайтай, муудаж гэмтээгүй гадны үнэр амтгүй ялзраагүй байх<br>• Байцааны дундаж жин нь 2-2.5 кг байх<br>• Гадаргууны илүүдэл навч, голыг цэвэрлэсэн байна.<br>**Барааны нэр: Бөөрөнхий сонгино**<br>• Ялзарч муудаагүй, хатаж чийгээ алдаагүй, ааг амт сайтай, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна.<br>• Орон нутагт тариалсан байна<br>• Соёолж, хөгшрөөгүй байхаас гадна 1ш сонгины дундаж жин 100-150гр байх.<br>• 100кг сонгино бүрт 2кг хорогдол тооцож байх<br>**Барааны нэр: Лууван**<br>• 1ш луувангийн дундаж жин 200-300гр байх ба механик элдэв хольцгүй, зөөлөрч муудаагүй, чийгээ алдаагүй соёолоогүй, гадны үнэр амтгүй байна.<br>• Лууванд агуулагдах коратин болон бусад төрлийн амин дэм нь алдагдаагүй, багавтар чихэрлэг амттай улбар шар өнгөтэй байна.<br>• 100кг лууван бүрт 2кг хорогдол тооцож түүнтэй тэнцэх хэмжээний лууван нэмж олгоно.<br>**Барааны нэр: Манжин**<br>• Шар, хүрэн манжин нь стандартын шаардлага хангасан байна.<br>• Гэмтээгүй, ялзарч муудаагүй, хөгшрөөгүй, шинэ байна.<br>• Гадаргууны шороо, үндэс, навчыг бүрэн цэвэрлэсэн байх |

| | | |
|---|---|---|
| | | **Барааны нэр: Нарийн ногоо / чинжүү, /**<br>• Хэт хөгшрөөгүй, чийгээ алдаагүй, хөгц үүсч муудаагүй, шинэ байна.<br>• Дундаж жин нь 250-280гр, 4-5см диаметртэй байна.<br>**Барааны нэр: Сармис**<br>• Ялзарч муудаагүй, хатаж чийгээ алдаагүй, ааг амт сайтай, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна.<br>• Орон нутагт тариалсан байна |
| **Багц 3** | **Сүү,сүүн бүтээгдэхүүний багц** | **Ерөнхий зүйл:**<br>• Нийлүүлэгдэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь стандартын шаардлага хангасан байна.<br>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ.<br>• Сүүг тээвэрлэх жолооч нь эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байх.<br>• Тээвэрлэхдээ зориулалтын нэг тээврийн хэрэгслээр зөөвөрлөх<br>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.<br>• 2013 оны “Хүнсний хууль” –ийг хэрэгжүүлсэн байна.<br>• Лабораторийн шинжилгээний болон гарал үүслийн бичигтэй байна.<br>• Нийлүүлэгдэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь эх орны бүтээгдэхүүн байна.<br>**Барааны нэр: Шингэн сүү**<br>• Эрүүл ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна.\ хуванцар бус сав\<br>• Гадны үнэр, амт байхгүй, тослог зохиох түвшинд байх, шинэ, шингэн болон хөлдөөсөн байна.<br>• Тээвэрлэлтийн горимыг баримтлана.<br>**Барааны нэр: Цагаа**<br>• Монгол аргаар бэлтгэсэн, стандартын шаардлага хангасан байна. /Хог хаягдал, шавьж хорхойгүй /<br>• Цагаан өнгөтэй<br>• Хэт исгэлэн гашуун, ахарсан, хөгцөрсөн биш байна.<br>• Аарц нь 30кг –аас дээшгүй савлагдсан хөлдүү байна.<br>**Барааны нэр: Пакеттай сүү**<br>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.<br>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ.<br>• Зориулалтын сав баглаанд савласан байна. /сав нь гэмтэж хагараагүй байна. /<br>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. /Элдэв өнгө амт, үнэргүй байна./<br>• Хадгалах хугацаа нь тодорхой заагдсан |

| | | |
|---|---|---|
| | | байх<br>**Барааны нэр:Тараг**<br>• Эрүүл ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна.\ хуванцар бус сав\<br>• Гадны үнэр, амт байхгүй, тослог зохиох түвшинд байх, шинэ, шингэн<br>• Исээгүй байх<br>Тээвэрлэлтийн горимыг баримтлана |
| **Багц 4** | **Гурил,гурилан бүтээгдэхүүн \талх нарийн боов** | **Ерөнхий зүйл:**<br>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.<br>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ.<br>• Зориулалтын сав баглаанд савласан байна.<br>• Зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.<br>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.<br>**Барааны нэр:Талх**<br>• Талхны хэмжээ 800 граммаас багагүй байна.<br>• Бутрамтай биш, нягтаршил, болц сайтай байна.<br>• 2013 оны “Хүнсний хуулийг хэрэгжүүлсэн” байна.<br>**Барааны нэр:Нарийн боов**<br>• Нийлүүлэх нарийн боов нь тослог, давхраат, өндгөн, хөөмөл, зуурмагаар бэлтгэгдсэн олон төрөл байна.<br>• Хэлбэр дүрсээ алдаагүй, өнгө үзэмж сайтай шинэ байна.<br>Хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн эрүүл хүнс байна. /аминдэм, ккал нь стандартын норм хангасан |
| | | **Барааны нэр: Давс**<br>• 0.5 -1кг-аар савлагдсан, чийг аваагүй, хуурай, бөөгнөрч хатуураагүй, иодын агууламж нь зохих түвшинд байна.<br>**Барааны нэр: Гурил**<br>• MNS 0244:2009 техникийн шаардлага хангасан байна.<br>• Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй байна.<br>• 1-р зэргийн тэмдэгтэй байна.<br>• 25-50кг-аар савлагдсан байх<br>• Чийгээ алдаагүй, шинэ<br>**Барааны нэр: Жимсний чанамал /Варень/**<br>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.<br>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ.<br>• Зориулалтын сав баглаанд савласан байна. |

| | | |
|---|---|---|
| | | /сав нь гэмтэж хагараагүй байна. /<br>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. /Элдэв өнгө амт, үнэргүй, усжаагүй, хөгцгүй байна./<br>**Барааны нэр: Ургамлын тос**<br>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.<br>• Зориулалтын сав баглаанд савласан байна.<br>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. /элдэв, өнгө, амт үнэргүй байна./<br>**Барааны нэр: Будааны төрөл /хүүхдийн будаа/**<br>• MNS 0142:1985 техникийн шаардлага хангасан байна.<br>• Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, бяцарч хуваагдаагүй байна.<br>• Цагаан будаа нь том ширхэгтэй, агшаахад нялцайхгүй байна.<br>**Гоймонгийн төрөл**<br>• Нийлүүлэгдэх гоймон нь үйлдвэрийн аргаар боловсруулагдсан олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн байна.<br>• 0.35-5 кг-аар савлагдсан, чийг аваагүй, хуурай, хөгцөрч муудаагүй, үйрч гэмтээгүй, хэлбэр дүрсээ алдаагүй, шинэ байна.<br>• Өндөгний хольцтой, урсамтгай биш, шинж чанартай байна.<br>• 5-аас доошгүй төрөл байна. **/лапша /**<br>**Барааны нэр: Бусад хүнс**<br>**• Хуурай цай /гүрж ногоон цай/**<br>**• Жамц давс**<br>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.<br>• Зориулалтын сав баглаанд савласан байна.<br>• Дагалдах бичиг баримтанд жолоочийн нэр, тээврийн хэрэгслийн дугаар, тоо хэмжээ, үнэ зэргийг тусгасан байна.<br>• 2013 оны хүнсний хуулийг хэрэгжүүлсэн байна.<br>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. /хөгц амтгүй байна./<br>• Хүнсийг тээвэрлэх жолооч нь эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байх.<br>• Тээвэрлэхдээ зориулалтын нэг тээврийн хэрэгслээр зөөвөрлөх |
| | | **Барааны нэр: Чацаргана**<br>• Стандартын шаардлага хангасан байна.<br>• Зориулалтын сав баглаанд савласан байна.<br>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна.<br>• Элдэв өнгө амт үнэргүй, хатаж хорчийгоогүй, хөгцгүй, шороо чулуугүй, хог хаягдалгүй, дээд зэргийн чанарынх |

| | | |
|---|---|---|
| **Багц 6** | **Жимс,жимсгэний багц** | байна.<br>• Шинэ жимс нь исээгүй, няцраагүй, хорхой идээгүй, хөгцрөөгүй, иш, навчгүй байна.Байгалийн жимсээрээ байх.<br>• Байгалийн жимс, жимсээрээ<br>**Барааны нэр:Варень**<br>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.<br>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ.<br>• Зориулалтын сав баглаанд савласан байна. /сав нь гэмтэж хагараагүй байна. /<br>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. /Элдэв өнгө амт, үнэргүй, усжаагүй, хөгцгүй байна./<br>**Барааны нэр:Зөгийн бал**<br>• Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна.<br>• Нийлүүлэгч нь өөрсдийн зардлаар захиалгын дагуу хүргэж ирнэ.<br>• Зориулалтын сав баглаанд савласан байна. /сав нь гэмтэж хагараагүй байна. /<br>• Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. /Элдэв өнгө амт, үнэргүй, усжаагүй, хөгцгүй байна./<br>• Хадгалах хугацаа тодорхой заасан байна |

**1. Баглаа боодол**

**Багц1:** Мах, махан бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах явцад гадны нөлөөлөлөөс хамгаалан гадуур нь гялгар уутаар ороосон байна.

**Багц 2:** Хүнсний ногоо тус тусдаа савлагдсан, гадны шороо чулууны хольцгүй байх

**Багц 3**: Сүү, сүүн бүтээгдэхүүнийг зориулалтын таглаатай ариутгасан саванд савлаж тээвэрлэх ба гашилж муудахаас хамгаалах

**Багц 4:** Талх, нарийн боовыг зориулалтын машинаар тээвэрлэхдээ тус тусад нь савлаж битүүмжилсэн байна.

**Багц 5:** Хуурай хүнсний багцад орсон бүтээгдэхүүн тус бүр зориулалтын саванд савлагдсан ба гадны тоос шороо орохоос сэргийлэн, хадгалах хугацаа нь тодорхой заагдсан, тээвэрлэлтийн явцад гэмтэж муудах, хагарч асгарахаас хамгаалагдсан байна.

**Багц 6:** Жимс, жимсгэний багцад орсон бүтээгдэхүүн тус бүр нь зориулалтын саванд савлагдсан байх ба гадны тоос шороо орохоос сэргийлэн , хадгалах хугацаа нь тодорхой заагдсан, тээвэрлэлтийн явцад гэмтэж муудах, хагарч асгарахаас хамгаалагдсан байна.

ХЭРЛЭН 10 ЦЭЦЭРЛЭГИЙН НЯРАВ Б.ЦЭВЭЛ